



МОНГОЛ УЛСЫН  
ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2015 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 1/295

Улаанбаатар хот

Аргачилсан зөвлөмж батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3, 28 дугаар зүйлийн 28.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх аргачилсан зөвлөмж”-ийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү аргачилсан зөвлөмжийн дагуу ажлын байранд учирч болох аюул ослыг арилгах, хяналт тавих, учирч болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийж, ажиллахыг ажил олгогч нарт зөвлөсүгэй.

САЙД



Г.БАЯРСАЙХАН

0000001811

Хөдөлмөрийн сайдын 2015 оны  
28 дугаар сарын 28-ны өдрийн  
1695 дугаар тушаалын хавсралт

## Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх аргачилсан зөвлөмж

### 1. Эрсдэлийн үнэлгээ хийх ажлын зорилго:

Аж ахуйн нэгж байгууллага учирч болзошгүй аюулаа урьдчилан судалж түүний дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөө боловсруулах, арга хэмжээний санхүүжилтээ төлөвлөх, аюулгүй ажиллагааны зөв удирдлага зохион байгуулалттай болох, ажлын байранд учирч болох аюул ослыг арилгах, хяналт тавих болон ажил олгогч "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль"-д заасан үүргээ хэрэгжүүлэхэд чиглэл өгөхөд оршино.

### 2. Үйлчлэх хүрээ:

Энэхүү аргачилсан зөвлөмжийг өмчийн хэлбэр харгалзахгүй Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа дотоодын болон гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн нийт ажлын байранд ашиглаж болно.

### 3. Ерөнхий зүйл

Ажилтны хөдөлмөрлөх явцад үүсч болзошгүй аюул түүнээс үүдэлтэй учирч болох эрсдэлийн хамрах хүрээг тодорхойлж, үнэлэлт өгөх үйл явцыг эрсдэлийн үнэлгээ гэнэ.

Энэхүү аргачлалаар багаар эрсдэлийн үнэлгээ хийх аргыг сонгосон болно.

Багаар эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалын давуу тал нь ажил олгогч, ажилтны төлөөллийг багтаасан, судалгаан дээр үндэслэсэн, эцсийн үр дүнг бүрэн тогтоодогоороо онцлогтой юм.

Ажлын байранд гарч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, түүнийг хянах, эрсдэлийг бууруулах зорилгоор аюулгүй ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах байнгын үйл явцыг хийж гүйцэтгэх арга барил эзэмшүүлэхэд эрсдэлийн үнэлгээний ач холбогдол оршино.

Аюул нь ямар нэгэн зөрчлийн улмаас бий болдог тул эрсдэлийн үнэлгээ хийхдээ зөрчлийг илрүүлж түүнийг арилгах арга хэмжээг зөв төлөвлөж, хэрэгжүүлэх нь чухал.

Эрсдэлийн үнэлгээ хийхдээ дараах зарчмыг баримтална.

#### а/. Ажилтны аюулгүй байдлыг судлах

/Тухайн ажлыг гүйцэтгэхэд ажилтны зүгээс аюулгүй ажиллах шаардлагыг хангаж байгаа эсэх/

#### б/. Ажлын байрны орчин, нөхцөл

/Хими, физик, биологи, физиологийн хүчин зүйлийг судлан үзнэ./

#### в/. Тоног төхөөрөмж, машин механизмын аюулгүй байдал


/ MNS 4930:2000 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага стандарт, тухайн тоног төхөөрөмжтэй холбоотой аюулгүй ажиллагааны дүрэм, журам, стандарт, зааврын дагуу судална./

#### г/. Удирдлага зохион байгуулалт

/Эрсдэлийн үнэлгээ хийж байгаа ажлын байр бүрт ХАБЭА-н удирдлага зохион байгуулалт ямар түвшинд байгааг судална./

#### 4. Үнэлгээ хийх шат дараалал

Эрсдэлийн үнэлгээг дараах шат дарааллаар хийнэ:



##### 4.1. Эхлэх буюу 1-р үе шатанд хийх ажил

###### 4.1.1. Эрсдэлийн үнэлгээ хийхийн өмнө бүрдүүлэх материал

- Эрсдэлийн үнэлгээ хийх ажлын байрны жагсаалтыг гаргах
- Үнэлгээ хийх гэж байгаа ажлын байртай холбогдсон аюулгүй ажиллагааны дүрэм, журам, стандартыг цуглуулах
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр өмнө нь авч хэрэгжүүлж байсан арга хэмжээний тайлан
- Хэмжилтийн багаж хэрэгсэл /Гэрэлтүүлэг, тоосжилт, дуу шуугиан, доргион, агаарын урсгалын хурд хэмжигч, термометр гэх мэт/
- Зургийн аппарат, проектор
- Ажилтнуудын эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт
- Хөдөлмөрийн чадвар алдалтын судалгаа
- Тоног төхөөрөмжийн жагсаалт
- Техник ашиглалтын паспорт хөтлөлт
- Тоног төхөөрөмжийг суурилуулсан акт, тусгай зөвшөөрөлтэй тоног төхөөрөмжид баталгаажилт хийсэн дүгнэлт, ажиллуулах зөвшөөрөл
- Хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, судалгаа хийсэн дүгнэлт
- Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн жагсаалт, ашиглалтын заавар, олгосон баримт бичиг
- Ажилтнуудын эрүүл мэндэд физиологийн судалгаа хийсэн дүгнэлт
- Ажилтнуудын ХАБЭА-н чиглэлээр сургалтанд хамрагдсан талаарх материал
- Боловсрол, мэргэжил эзэмшсэн талаарх баримт бичгийн хуулбар

###### 4.1.2. Баг бүрдүүлэх

Эрсдэлийн үнэлгээ хийх багийг тухайн ажлын байранд ажилладаг ажилтан, инженерийн төлөөллөөс бүрдүүлэх нь чухал. Тухайлбал:

Ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийхдээ тухайн чиглэлийн инженер, мэргэжлийн ажилтныг багт оруулан ажиллуулах нь учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх түүнийг зөв үнэлж, дүгнэхэд тэдний мэдлэг, туршлагыг ашиглан эрсдэлийг бодитой үнэн зөв тогтооход ач холбогдолтой юм.

Эрсдэлийн үнэлгээ хийх багийн бүрэлдэхүүн нь ажлын байрны онцлогоос шалтгаалан 3-аас доошгүй байвал зохимжтой.

##### 4.2. Үнэлгээ хийх ажлын байраа сонгох буюу 2-р шатанд хийгдэх ажил

- Үнэлгээ хийх ажлын байрыг төрөл тус бүрээр ангилж сонголт хийнэ.
- Тухайн ажлын байрыг бүрдүүлж байгаа ажилбараар нь ялгана.

- Ажилбарыг дамжлагын дарааллаар цэгцлэнэ.
- Үнэлгээ хийх ажлыг төрөл тус бүрээр ангилж, эрсдэлийн үнэлгээ хийхээр төлөвлөж, үнэлгээний объект, цар хүрээг тогтооно.

**Жишээ нь: Газар шорооны ажил гүйцэтгэх ажлын байрыг сонгоё.**

- 1-р ажилбар хөрсөө судлах
  - 2-р ажилбар хөрс хуулах
  - 3-р ажилбар хөрсөө ачих
  - 4-р ажилбар хөрсөө зөөх
  - 5-р ажилбар хөрсөөр овоолго хийх
  - 6-р ажилбар ул тэгшлэх г. м
- 4.3. **Зөрчлийг илрүүлэх буюу 3-р шатанд хийгдэх ажил.**  
Аюултай хүчин зүйлийг илрүүлэхийн тулд ерөнхий суурь зарчмыг үндэслэн судалгаа авах маягт 1 -ийн дагуу боловсруулна.
- 4.4. **Эрсдэлийн түвшинг тогтоох буюу 4-р шатанд хийгдэх ажил.**
- Эрсдэлийн түвшинг тогтоохын тулд дараах үнэлгээний хүснэгтүүдийг ашиглана.

Хүснэгт 1.

ЗӨРЧИЛ ҮҮСЭХ МАГАДЛАЛ	Давтагдах хугацаа	P
Тохиолдлын	3 - 5 жилд	1
Бага магадлалтай	Нэг жилд	2
Магадлалтай	Улиралд	3
Өндөр магадлалтай	Сард	4
Тогтмол	Долоо хоногт	5

Хүснэгт 2.

ЗӨРЧЛӨӨС ШАЛТГААЛАХ ҮР ДАГАВАР	Тусламж авах хугацаа	N
Хөдөлмөрийн чадвар алдагдах байдалд хүргэхгүйгээр эрүүл мэндэд бага хэмжээний хохирол учруулах гэмтэл	Түр саатах	1
Хөдөлмөрийн чадвар алдалттай боловч эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагагүй хөнгөн гэмтэл	Ээлжийн дотор	2
Эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх шаардлагатай ноцтой гэмтэл	4 хоног хүртэл	3
Удаан хугацааны эмчилгээ шаардагдах хүнд гэмтэл	4 хоногоос дээш	4
Амь нас эрсдэхэд хүргэх гэмтэл	Удаан	5

Хүснэгт 3.

ГИШҮҮДИЙН САНАЛ	N
Гэмтэл, бэртэлд хүргэх маш бага магадлалтай	1
Гэмтэл, бэртэлд хүргэх бага магадлалтай	2
Гэмтэл, бэртэлд хүргэх их магадлалтай	3
Гэмтэл, бэртэлд хүргэх үлэмж их магадлалтай	4

Эдгээр хүснэгтийг ашиглан Маягт 2-ын дагуу бодолт хийнэ.

**4.5. Эрсдэлийг үнэлж тогтоосноор учирч болох аюулыг арилгах арга хэмжээг авах буюу 5-р шатанд хийгдэх ажил**

4-р шатанд хийсэн үнэлгээний дагуу ажлын төлөвлөгөө гаргаж, түүнийг хариуцсан ажилтан, учирч болох аюулыг арилгах хугацаа, санхүүжилтийг маягт 3-т заасны дагуу боловсруулна.

**Эрсдэлийн үнэлгээгээр илэрсэн зөрчлийг арилгахын тулд дараах арга хэмжээний аль тохирохыг сонгоно.**

- Засах /Тоног төхөөрөмжийн хаалт эвдэрсэн гэж дүгнэгдвэл түүнийг засаж болно./
- Орлуулах /Засаж болохгүй хаалт байвал түүнийг өөр зүйлээр орлуулж болно./
- Шинэчлэх /Хаалтыг орлуулах, засах боломжгүй бол шинээр худалдан авна./
- Хамгаалах хэрэгсэл хэрэглэх /Хувийн болон нийтийн хамгаалах хэрэгсэл/

**5. Эрсдэлийн үнэлгээний дүн бодитой эсэхийг шалгаж, авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, ажилтнуудад үнэлгээний дүнг танилцуулж, сургалт зохион байгуулна.**

- Эрсдэлийн үнэлгээ оновчтой байгаа эсэхийг шалгана.
- Эрсдэлийн түвшинг үндэслэн илэрсэн зөрчлийг арилгахаар төлөвлөсөн арга хэмжээ нь бодитой, үр дүнтэй байж чадах эсэхийг шалгана.
- Үнэлгээний үр дүнгийн талаар тайлан гаргах.
- Эрсдэлийн үнэлгээний дүнд эрсдэлийг бууруулах арга хэмжээг ажилбар тус бүрээр гарган авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, удирдлагад танилцуулах ба ажилтан, ажил олгогч нарын оролцоотойгоор илрүүлсэн зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах
- Сайжруулж төлөвлөх

**Эрсдэлийн үнэлгээг дараах тохиолдлуудад хийнэ. Үүнд:**

1. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа тохиолдолд жилд 1 удаа
2. Осолд дөхсөн тохиолдолд эсвэл осол гарсан тухай бүр
3. Ажилтан шинээр ажилд орсон үед
4. Шинээр тоног төхөөрөмж авсан буюу тоног төхөөрөмжийн байрлал сольсон үед

## Зөрчлийг илрүүлэх судалгаа авах маягт 1

Маягт 1.1: Ажилтнаас шалтгаалах зөрчил

Овог нэр  
Албан тушаал  
Цех тасаг  
Нас  
Хүйс

№	Зөрчил	P	N	H
1.	ХАБЭА-н сургалтанд хамрагдаагүйгээс			
2.	Эрүүл мэндийн хувьд тухайн ажилд тэнцээгүйгээс			
3.	Хийх ажлаа мэддэггүйгээс			
4.	Мэргэжлийн сургалтанд хамрагдаагүйгээс			
5.	Ажлын хувцас хамгаалах хэрэгслээ зөв хэрэглэж сураагүйгээс			
6.	Ажлын байрандаа хяналт хийдэггүйгээс			
7.	Анхан шатны эмнэлгийн тусламж үзүүлж чадаагүйгээс			
8.	Онцгой байдлын үед өөрийгөө болон бусдыг аврах мэдлэггүйгээс			
9.				
10.				
11.				
12.				
13.				
14.				
15.				
16.				

**Тайлбар:** Тухайн ажлын байрны онцлогт тохируулан судалгааны асуулгыг өөрчилж хэрэглэнэ.

Маягт 1.2. Тоног төхөөрөмжөөс шалтгаалах зөрчил

Тоног төхөөрөмжийн нэр

Марк

Ашиглалтанд орсон огноо

Цех тасгийн нэр

№	Зөрчил	P	N	H
<b>Цахилгаан тоног төхөөрөмж</b>				
1.	Цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглах, ажиллуулах зааваргүйгээс			
2.	Цахилгаан тоног төхөөрөмжийн газардуулга хийгдээгүйгээс			
3.	Техник ашиглалтын паспорт хөтлөөгүйгээс			
4.	Тоног төхөөрөмжийн удирдлагын систем бүрэн бишээс			
5.	Аваарийн зогсоогуур суурилуулаагүйгээс			
6.	Зөв суурилуулалт хийгээгүйгээс			
7.				
8.				
<b>Даралтат сав , шугам хоолой</b>				
9.	Ашиглах зөвшөөрөлгүйгээс			
10.	Даралтын баталгаажилт хийгдээгүйгээс			
11.	Хэмжих хэрэгслийг баталгаажуулаагүйгээс			
12.	Металлын шинжилгээ хийгээгүйгээс			
13.	Хамгаалах хавхлаг ажилладаггүйгээс			
14.				
<b>Өргөх зөөх механизм</b>				
15.	Даацын баталгаажилт хийгээгүйгээс			
16.	Оосорлох хэрэгслийг туршаагүйгээс			
17.	Тоормосны механизм гэмтэлтэйгээс			
18.	Хязгаарлалт ажилладаггүйгээс			

Багаж хэрэгсэл, түүхий эд материал			
19.	Багаж хэрэгслийн бариул эргономикийн шаардлага хангаагүйгээс		
20.	Багаж хэрэгслийг зөв байрлуулаагүйгээс		
21.	Багаж хэрэгслийн эвдрэлээс		
22.	Ашиглах зөвшөөрөл аваагүйгээс		
23.	Түүхий эд материалын бохирдолтоос		
24.	Түүхий эд материалыг зөв хадгалаагүйгээс		
25.			

**Тайлбар:** Химийн бодис, уур усны ялгаруулалт гэх мэт тоног төхөөрөмжид тавигдах аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага стандарт, ямар тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд эрсдэлийн үнэлгээ хийж байна гэдгээс хамаарч тухайн тоног төхөөрөмжид тавигдах аюулгүй ажиллагааны судалгаа авахдаа онцлогоос шалтгаалан асуулгыг өөрчилж болно.

Маягт 1.3. Ажлын байрны орчин, нөхцөлөөс шалтгаалах зөрчил

Ажлын байрны нэр  
Цех тасгийн нэр  
Ажил мэргэжлийн нэр

№	Зөрчил	P	N	H
<b>Физикийн хүчин зүйл</b>				
1.	Ажлын байрны агаарын температур зөвшөөрөгдөх хэмжээнээс их ба бага			
2.	Агаарын урсгалын хурд зөвшөөрөгдөх хэмжээнээс их ба бага			
3.	Харьцангуй чийглэг зөвшөөрөгдөх хэмжээнээс их ба бага			
4.	Гэрэлтүүлэг зөвшөөрөгдөх хэмжээнээс бага			
5.	Дуу, шуугиан зөвшөөрөгдөх хэмжээнээс их			
6.	Доргион зөвшөөрөгдөх хэмжээнээс их			
7.	Цахилгаан соронзон орон зөвшөөрөгдөх хэмжээнээс их			
8.				
<b>Химийн хүчин зүйл</b>				
9.	Угаарын хий зөвшөөрөгдөх хэмжээнээс их			
10.	Нүүрсхүчлийн хий зөвшөөрөгдөх хэмжээнээс их			
11.	Азотын исэл зөвшөөрөгдөх хэмжээнээс их			
12.	Хүхэрлэг ангидрид зөвшөөрөгдөх хэмжээнээс их			
13.	Хүхэрт устөрөгч зөвшөөрөгдөх хэмжээнээс их			
14.				
<b>Биологийн хүчин зүйл</b>				
15.	Ажлын байран дахь хөгц мөөнгөнцөр үүссэн			
16.	Халдвартай материалтай харьцаж ажилладаг			
17.	Ажилтнуудын цайны газрын ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангалтгүй			
18.	Бие засах, усанд орох газрын ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангалтгүй			
19.	Өвчин үүсгэгч жижиг организмаас халдварлах (бактер, вирус )			
20.				

Тайлбар: Тухайн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд хийсэн дүнг үндэслэж энэхүү маягтыг бөглөнө.

Маягт 1.4 Ажил олгогч, удирдлагаас шалтгаалах зөрчил

Цех тасгийн нэр  
Ажлын байрны нэр  
Удирдагчийн нэр

№	Зөрчил	P	N	H
1.	Аюулгүй байдлын төлөвлөгөөгүйгээс			
2.	Эрсдэлийн үнэлгээ хийгээгүйгээс			
3.	ХАБЭА-н санхүүжилтийг зөв төлөвлөөгүйгээс			
4.	Дотоодын хяналт хийдэггүйгээс			
5.	Ажлыг гүйцэтгэх дэс дарааллыг зөв тогтоогоогүйгээс			
6.	Ажил эхлэх, дуусах болон явцын хяналтыг хийдэггүйгээс			
7.	Осол болон осол дөхсөн тохиолдлыг судалдаггүйгээс			
8.				
9.				

Тайлбар: Ажлын байр тус бүрээр ажил олгогч, удирдлагаас шалтгаалах зөрчлийн судалгааг дээрх маягтын дагуу авна.

Маягт 2. Эрсдэлийн түвшинг тогтоох нэгдсэн хүснэгт

Багийн гишүүд	Эрсдэлийн түвшин	Ажилтнаас шалтгаалсан зөрчил						
		Асуулт 1	Асуулт 2	Асуулт 3	Асуулт 4	Асуулт 5	Асуулт 6	Асуулт 7
1-р гишүүний нэр	P							
	N							
	H							
2-р гишүүний нэр	P							
	N							
	H							
3-р гишүүний нэр	P							
	N							
	H							
Нийт дундаж үнэлгээ	P							
	N							
	H							
Тоон үнэлгээ								
Үсгэн үнэлгээ								

Багийн гишүүд	Эрсдэлийн түвшин	Тоног төхөөрөмжөөс шалтгаалсан зөрчил						
		Асуулт 1	Асуулт 2	Асуулт 3	Асуулт 4	Асуулт 5	Асуулт 6	Асуулт 7
1-р гишүүний нэр	P							
	N							
	H							
2-р гишүүний нэр	P							
	N							
	H							
3-р гишүүний нэр	P							
	N							
	H							
Нийт дундаж үнэлгээ	P							
	N							
	H							
Тоон үнэлгээ								
Үсгэн үнэлгээ								

Багийн гишүүд	Эрсдэлийн түвшин	Ажлын байрны орчин, нөхцөлөөс шалтгаалсан зөрчил						
		Асуулт 1	Асуулт 2	Асуулт 3	Асуулт 4	Асуулт 5	Асуулт 6	Асуулт 7
1-р гишүүний нэр	P							
	N							
	H							
2-р гишүүний нэр	P							
	N							
	H							
3-р гишүүний нэр	P							
	N							
	H							
Нийт дундаж үнэлгээ	P							
	N							
	H							
Тоон үнэлгээ								
Үсгэн үнэлгээ								

Багийн гишүүд	Эрсдэлийн түвшин	Ажил олгогч, удирдлагаас шалтгаалсан зөрчил						
		Асуулт 1	Асуулт 2	Асуулт 3	Асуулт 4	Асуулт 5	Асуулт 6	Асуулт 7
1-р гишүүний нэр	P							
	N							
	H							
2-р гишүүний нэр	P							
	N							
	H							
3-р гишүүний нэр	P							
	N							
	H							
Нийт дундаж үнэлгээ	P							
	N							
	H							
Тоон үнэлгээ								
Эрсдлийн зэрэг								

**Тайлбар:**

1. Нийт дундаж үнэлгээг өгөхдөө гишүүд тус бүрийн P,N,H магадлалуудад өгсөн үнэлгээний нийлбэрийн дундажаар гаргана.

2. Тоон үнэлгээг гаргахдаа ( $P \times N \times H$ ) үржвэрээр гаргана.
3. Эрсдэлийн түвшинг тооцоходоо тоон үнэлгээний дүнг харгалзан дараах хүснэгтийн дагуу арга хэмжээ авна

$$R = P \times N \times H$$

R – Эрсдэлийн түвшин

P – Зөрчил үүсэх магадлал

N – Зөрчлөөс шалтгаалах үр дагавар

H – Гишүүдийн санал

Эрсдэлийн ангилал, зэрэг, авах арга хэмжээ. **Хүснэгт 4.**

ЭРСДЭЛИЙН АНГИЛАЛ	ЭРСДЭЛИЙН ТҮВШИН R	Авах арга хэмжээ
A	R ≥ 100 үл зөвшөөрөгдөх хэмжээний эрсдэл	Эрсдэлийн түвшин нь маш өндөр байна. Зөрчлийн нөлөөлөл хүчин зүйлс нь бэртэл, гэмтэл, ноцтой осолд хүргэж болзошгүй учраас ажлыг гүйцэтгэж эхлэх ба үргэлжлүүлж болохгүй. Хэрэгжүүлэх арга хэмжээний зардал, өртгөөс үл хамааран эрсдэлийг нэн даруй бууруулах арга хэмжээ авах шаардлагатай.
B	R = 51-99 тохиромжгүй, ихээхэн хэмжээний эрсдэл	Эрсдэлийн түвшин нь өндөр байна. Эрсдэлийг илүү хүлээн зөвшөөрөхүйц түвшин хүртэл бууруулах, аюулгүй байдлын арга хэмжээг яаралтай авахад чиглэгдсэн хөрөнгийг гаргах шаардлагатай.
C	R = 11-50 дундаж хэмжээний эрсдэл	Эрсдэлийн түвшин нь дундаж хэмжээтэй байна. Хэдийгээр яаралтай биш ч гэсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн норм, дүрмийн дагуу аюулгүй байдлыг хангах арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх шаардлагатай.
D	R = 4-10 Зөвшөөрөгдөх хэмжээний эрсдэл	Эрсдэлийн түвшин нь бага байна. Ажил гүйцэтгэх үед тогтмол хяналт тавьж, эрсдэлийг удирдах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн норм, дүрмийг хатуу мөрдлөг болгох шаардлагатай.
E	R = 1-3 бага хэмжээний эрсдэл	Эрсдэлийн түвшин нь маш бага байна. Эрсдэлийг удирдах онцгой арга хэмжээ шаардлагагүй боловч, үүнийг 100% аюулгүй нөхцөл байдлыг хангасан гэж үзэж болохгүй.

**Маягт 3. Эрсдэлийг тогтоосноор зөрчлийг арилгах төлөвлөгөө боловсруулах**

Ажилбарын нэр	Хүчин зүйл	Үүссэн зөрчил	Эрсдэлийн түвшин R	Авах арга хэмжээ	Хариуцах ажилтан	Хугацаа	Санхүүжилт
	Ажилтан	1. Зөрчил 1 2. Зөрчил 1 3. Зөрчил 1 4. Гэх мэт	A C B D	Авах арга хэмжээ 1 Авах арга хэмжээ 2 гэх мэт			
	Тоног төхөөрөмж	1. Зөрчил 1 2. Зөрчил 1 3. Зөрчил 1 4. Гэх мэт	C B A E	Авах арга хэмжээ 1 Авах арга хэмжээ 2 гэх мэт			
	Ажлын байрны орчин, нөхцөл	1. Зөрчил 1 2. Зөрчил 1 3. Зөрчил 1 4. Гэх мэт	A B C D	Авах арга хэмжээ 1 Авах арга хэмжээ 2 гэх мэт			
	Ажил олгогч буюу удирдлага	1. Зөрчил 1 2. Зөрчил 1 3. Зөрчил 1 4. гэх мэт	D A C E	Авах арга хэмжээ 1 Авах арга хэмжээ 2 гэх мэт			

**Тайлбар:** Төлөвлөгөөний дагуу зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах албан тушаалтныг тодорхой болгож өгөх хэрэгтэй. Ингэхдээ тухайн ажилтны ажлын байрны тодорхойлолтыг үндэслээрэй. Тухайн зөрчлийг арилгахын тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилтийг тодорхойлохдоо зах зээлийн үнийг баримтлаарай.

Тухайлбал: Тоног төхөөрөмжөөс шалтгаалсан зөрчилд авах арга хэмжээ:

- Засах
- Орлуулах
- Шинэчлэх
- Хамгаалах хэрэгсэл хэрэглэх